



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/292

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас санаачилан хэрэгжүүлж байгаа “Бизнесийн сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний зардалд 3,000,000 (Гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,000,000 (Гурван сая) төгрөгийг “Эрх зүй нийгмийн хэв журам хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах арга хэмжээний” зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд, удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тайлагнахыг аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга (Д.Гэрэлтуяа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

6717010911

Захирамж2024